

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН

ГАЗРЫН ДАРГА

Б.БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН “АЯНЧИН ФООР СИЙЗОНЗ

ЛОДЖ” ХХК ЗАХИРАЛ

Б.БИЛГҮҮН

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРЭГ,
ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН “ЭРЭЭНИЙ АДАГ” НЭРТЭЙ ГАЗАР ХЭРЭГЖИЖ
БУЙ “АЯНЧИН ЛОДЖ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:

АЯНЧИН ФООР СИЙЗОНЗ ЛОДЖ ХХК-ИЙН

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН

О.Өнөржаргал

Улаанбаттар хот

2025 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

- a. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ
- b. ТӨСЛИЙН БАЙРШИЛ
- c. ХОГ ХАЯГДАЛ

- 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ
- 3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
- 4. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨДӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ
- 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
- 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
- 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
- 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
- 9. ХОГ ХАГЯДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
- 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР
- 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
- 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ
- 13. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр	“Аянчин фоор сийзонз лодж” аялал, жуулчлал
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Аянчин фоор сийзонз лодж” ХХК
Хаяг	Налайх дүүргийн 6р хороо, Горхи тэрэлж, Эрээний адаг, “Аянчин лодж” амралтын газар
Улсын бүртгэлийн дугаар	2911001070
Регистрийн дугаар	2872595

Төслийн зорилго

Энэхүү төслийн зорилго нь гадаад дотоодын жуулчдыг хүлээн авах, аялал жуулчлал, амралтын газар байгуулах, зочдын ая тухтай амрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, зэрэглэл, бүхий олон улсын болон дотоодын аялал жуулчлалын үйлчилгээ явуулж өөрийн оронд аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүрээлэн буй орчноо хамгаалж жишиг амралтын газар байгуулахад оршино.

1.1. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

“Аянчин фоор сийзонз лодж” ХХК-ийн Горхи-Тэрэлжийн БЦГ-ын эрээний адагт хэрэгжүүлж буй “Аянчин фоор сийзонз лодж” аялал жуулчлалын төслийг компаниас хэрэгжүүлж буй жуулчлалын цогц баазын нэгдүгээр үе шатны ажил бөгөөд энд гэр бааз байгуулсан. Манай бааз нь нэг ээлжиндээ өвлийн улиралд 28, зуны улиралд 78 хүн жилд дунджаар 4250хүн хүлээн авч, үйлчлэх хүчин чадалтай.

Үндсэн байгууламжинд 2 давхар термоблок бетонон байшин 1ш, 2 давхар текмоден байшин 1ш, зуны модон байшин 8ш, Монгол гэр 12ш, бага оврын цэвэрлэх байгууламж, бохир усны сан, гүний худаг, тоглоомын талбай, автомашины граж, ажилчдын байраас бүрдэх бөгөөд жилийн 4 улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулж, нийт 11 хүн тогтмол ажилладаг.

“Аянчин фоор сийзонз лодж” ХХК нь 2005 оноос хойш үйл ажиллагаа явуулж, Байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээг “Эко говь” ХХК, 2016 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг “Грийн Ассесмент” ХХК тус тус боловсруулан БОАЖЯ-аар батлуулсан байна. Мөн 2017 оноос үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлж, Америк гэр 5ш, 8 автомашины дулаан граж нэмж байгуулсан.



Зураг 1. Үндсэн байгууламж



Зураг 2. Дотор цайны газар

Төслийн талбайд өргөтгөл хийж 1 давхар сендвичэн байшин 4ш барьсан болно.


Бүтэц зохион байгуулалт:

- ❖ Зочны өрөө
- ❖ Унтлагын 2 өрөө
- ❖ Ариун цэврийн өрөө
- ❖ Үүдний өрөө
- ❖ Коридор зэргээс бүрдэнэ



1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Тус амралт, жуулчны бааз хүртэл Улаанбаатар хоттой засмал замаар холбогдсон. Улаанбаатар хотоос 51.3 км, Налайх дүүгээс 15 км зайд оршино. Улаанбаатар-Тэрэлжийн төв засмал замаас салаад сайжруулсан шороон замаар 0.6 км явж хүрдэг.



Зураг №4. Төслийн талбайн байршлын тойм зураг

Тус бааз нь Байгаль орчин, Аялал жуулчлалын яаманд 2022 оны 08 дүгээр сарын 4-ны өдөр гэрээ, гэрчилгээ сунгах хүсэлтээ өгсөн бөгөөд 2023 оны 08 сарын 01-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт ачлал жуулчлалын зориулалтаар газар ашиглах 0232988 дугаартай гэрчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 20 оны 09 сарын 07 өдрийн А/263 дугаартай тушаалаар 5 жилийн хугацаатай авсан.

Хүснэгт 1. Талбайн эргэлтийн цэг

№	Өргөрөг			Уртраг		
1	47	51	37.085	107	23	50.935
2	47	51	41.821	107	24	11.012
3	47	51	40.981	107	24	18.288
4	47	51	34.022	107	24	19.336
5	47	51	31.42	107	24	12.176
6	47	51	34.603	107	23	52.664

1.3. ХОГ ХАЯГДАЛ

Хатуу хог хаягдал

Ахуйн: Төслийн талбайд ажиллагсдын ахуйн хатуу хог хаягдал гарахаар байна. Хатуу хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгж буюу Налайх дүүргийн ОНӨААҮГ-тай гэрээгээр зайлуулна.

Харин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний явцад ашиглалтаас бүр мөсөн гарсан сэлбэг хэрэгсэл зэрэг зүйлс гарч болох юм. Тэдгээрийг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдэд тушаах, дахин ашиглах зэрэг арга хэмжээ авна.

Үйл ажиллагааны үед дээрх хүчин чадлыг үндэслэн Засгийн газрын 2017 оны 12-р сарын 25-ны өдрийн А/368-р тушаалын хавсралт “Хог хаягдлын нормативхэмжээг тогтоох аргачлал” -ын дагуу тооцвол зуны улиралд хоногт дунджаар 133.5 кг, сард 4тн, зуны улиралд нийт 36 тн орчим хог гарна.

Өвлийн улиралд хоногт дунджаар 58.5 кг, өвлийн улиралд сард 1.7 тн, өвлийн уоиралдаа 5.2тн орчим хог гарна. Жилдээ нийт 94.5 тн орчим хог гарна.

Шингэн хаягдал

Төслийн ус хэрэглээ: Усны нийт хэрэглээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 7-р сарын 30-ны өдрийн А/301-р тушаалар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцож хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Шаардлагатай усны хэмжээ

№	Ус хэрэглээний төрөл	Улирал	Тоо хэмжээ	Норм	Хоногийн хэрэглээ м³	Сарын хэрэглээ м³	Жилийн хэрэглээ м³
1	Амрагчид	Өвөл	28	200/л зочин хоног	5.6	168	504
2		Зун	78		15.6	468	4212
3	Ажилтан	-	11	80/л ажилтан хоног	0.9	27	324
Өвлийн улиралд бүгд					7.3	195	828
Зуны улиралд бүгд					16.5	495	4536

Нийт 1657 м² талбайд ногоон байгууламж байгуулсан байна.


Хүснэг 3. Усалгаанд шаардлагатай усны хэмжээ

№	Усалгааны төрөл	Усалгааны норм	Усалгаа хийх талбайн хэмжээ	Нэг удаа усах усны хэмжээ, м³	Жилд усах усны хэмжээ, м³
1	Цэцэрлэг, зүлэг ногоо усах	4.0 л/м²	1657м²	6.6	198
Бүгд					198

Жич: Усалгаа өдөр бүр хийгдэхгүй, жилд дунджаар хуурайшилттай үед 30 хоногт хийгдэнэ гэж тооцсон болно.

Уг тооцооноос харахад төслийн 1 жилийн үйл ажиллагаанд хоногт усалгаагүй үед Өвлийн улиралд 7.3м^3 , зуны улиралд 16.5м^3 , усалгаатай зед Өвлийн улиралд 13.9м^3 , зуны улиралд 23.1м^3 , жилд **5238м^3** ус шаардлагатай байна.

“Аянчин Фоор Сийзонз Лодж” аялал жуулчлалын газар нь цэвэрлэх байгууламж байгуулсан ба хоногт 10тн ахуйн бохир усыг цэвэрлэх чадалтай байна.



Зураг 6. Цэвэрлэх байгууламжийн зураг

Хаягдал ус цэвэрлэх байгууламжаас гарч байгаа ус нь “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015” стандартад нийцсэн байх ёстой ба уг усыг ногоон байгууламжийн усалгаа болон бочкиний усанд эргүүлэн ашиглахаар төлөвлөж байна.

Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай “Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ”-ний дагуу бохирын лагийг “Чандмань налайх” цэвэрлэх байгууламжид зайлуулдаг байна.



Зураг7. Цэвэрлэх байгууламжийн байршил

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Уур амьсгал. Тэрэлжийн “Аянчин Лодж” цогцолбор нь Хэнтийн нуруунаас эх авсан үзэсгэлэнт Тэрэлжийн аялал жуулчлалын хүрээнд далайн түвшинээс 1650 м орчим өргөгдсөн.

Уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс, хахир ширүүн Хэнтийн нурууны өвөр талын уул хөндийн цаг агаарын шинжтэй, хавар намартаа сэрүүн, өвөлдөө хүйтэн уул-хөндийн салхины жавартай жиндүү, зуны улирал харьцангуй богино чийглэг-хүйтэн уур амьсгалтай.

Бааз орчимд үнэмлэхүй бага температур өвөл хамгийн хүйтэн -41. С, хоногийн дундаж температур 11-14. С, үнэмлэхүй их температур 33-37. С тус тус ажиглагдаж температурын агууриг 78. С хүрсэн. Хөрсний температур цасан бүрхүүлтэй өвлийн улиралд агаарынхаас 5-7. С хүйтэн, дулаан улиралд 5-7. С халуун байдаг.

Агаарын даралт жилдээ Улаанбаатар хот орчмоос 10-20гПа-аар бага 840 гПа, зуны саруудад буурч 830-835 гПа, өвлийн саруудад тогтворто өсөж 845-850 гПа хүрч байна.

Нийт хур тунадасны 75% нь зуны 3-8 саруудад орох бөгөөд жилд дунджаар 250-300 мм хур тунадас байна. Агаарын харьцангуй чийгшил 76% хүрнэ, агаар дахь усны уур буюу үнэмлэхүй чийгшил жилд дунджаар 4-5.5 гПа, өвлийн улиралд 0.8-1.3 гПа, зуны улиралд 8-11 гПа болдог.

Салхины ноёлох чиглэл уул хөндийн онцлогтой. Өдрийн цагт Туул голын хөндийгөөс, шөнийн цагт уулын өндөрлөгөөс хөндий рүү чиглэлтэй салхи ноёлно. Салхины зонхилох чиглэл нь баруун, баруун хойд, хойд зүгээс байх бөгөөд салхины дундаж хурд 2.4-4.9 м/с хүрдэг.

Хөрсөн бүрхэвч. Төслийн талбайн орчмын хөрсөн бүрхэвчид уулын ойн ширэгт бараан хөрс, уулын хар шороон хөрсний хэв шинж зонхилох бөгөөд ялзмагт давхрагын зузаан харилцан адилгүй, дов толгодын орой хэсэгт 2.1-2.4%, жалга судаг дагаж нугажсан өтгөн өвстэй газар 5-5.4%, дунджаар 3.6%-ийн ялзмагтай байна.

Жуулчны баазын талбайд хөрсний төлөв байдлыг тодруулж үнэлгээ өгөх зорилгоор 2017 оны 5 сарын 05 өдөр хээрийн судалгаа хийсэн. Үүнд хөрсний гадаргын төлөв байдал өөрчлөлт, хөрсний үе давхаргын морфологи шинж чанар, хөрсөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулан хөрсний хими, физик шинж чанарын төлөв байдлыг тодруулах зорилгоор 2 дээж авч ШУА, Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид шинжлүүлсэн.

Шинжилгээгээр хөрсний дээд давхаргад агуулагдах ялзмагийн хэмжээ 8.35-15.92%, хөнгөн шавранцар хөрсөнд арай илүү агуулагдаж, хөрсний урвалын орчин ерөнхийдөө саармаг буюу 6.62-6.74 мг-экв/100г байна. Хөрсөн эх ширхэгийн бүрэлдэхүүний нунтаг шорооны агууламжийг авч үзэхэд хөнгөн шавранцар хөрсөнд дунд ширхэгтэй элс 2-0.05 мм-т 54.4-55.5%, бүдүүн тоос 0.05-0.002 мм-т 30.8-33.1%, шавар<0.002 мм-т 11.4-15.8% хэмжээтэй байна.

Дээрхээс үзэхэд тухайн хөрс үржил шимийн шинж чанараараа сайн, эрдэс болон шим тэжээлийн бодисоор хангамжтай сайн байна.

Ургамлан нөмрөг. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь ургамал газарзүйн мужлалаар Евроазийн шилмүүст ойн мужийн Өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрог, Евроазийн хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн хошууны Өрнөд Хэнтийн уулын хээрийн тойрог, Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрог, Улзын уулын хээрийн тойрогт хамаарагдана.

Тус нутагт ургамалжилтын босоо бүслүүрийн өндөр уул, ойн, уул хээр гэсэн 3 үндсэн бүслүүр зонхилно. Судалгааны дүнгээс үзэхэд 85 овгийн 389 төрөлд хамаарагдах 1229 зүйл гуурст дээд ургамалтай болохыг тогтоосон байна.

Тухайн нутаг нь уул нуруу, хотгор гүдгэр, гол шанд ихтэй учраас ургамал нь экологийн янз бүрийн нөхцөлд, янз бүрийн орчинд ургаж байдаг. Тухайлбал: Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт ургаж байгаа 1229 зүйл ургамлаас хээрийн 455 зүйл, ойн 503 зүйл, нугын 454, намгийн 145, тундрийн 185, хад асганы 114, усны болон голын эрэг хавийн 101, хужир мараатай газрын 19, хөл газрын 49 зүйл ургамал тус тус ургаж байна.

Мөн тухайн нутгийн ургамлын аймгийн зүйлийн бүрдлийг амьдралын хэлбэрээр авч үзвэл олон наст 954 зүйл буюу бүх ургамлын 78.2 хувийг эзлэх бөгөөд 29 зүйл, сөөг 71, хагас сөөг 12, сөөгөнцөр 15, хагас сөөгөнцөрхөн 9, нэг наст 94, хоёр наст 29, усны ургамал 16 зүйлтэй.

Амьтны аймаг. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар 6 баг, 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй зүйл буюу манай орны хөхтний зүйлийн 40 шахам хувьтай тэнцэх хөхтөн амьтан бий. Хөхтнөөс шавьж идэштэн 5, сарьсан далавчтан 4, туулай хэлбэртэн 4, мэрэгчид 4, мэрэгчид 19, мах идэштэн 13, туурайтан 5, мөлхөгч 1 байгааг судлаачид тогтоосон байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын ойн хортон шавьжийн зүйлийн бүрэлдэхүүнд 7 баг, 114 зүйл шавьж бүртгэгдээд байна.

Хэнтийн нуруунд нийт 253 зүйл шувуу бүртгэгдсэн байдгаас 180 зүйл нь өндөглөж зусдаг. Судалгаанд хамрагдсан нутагт 37 овогт хамаарах 149 зүйл шувууг бүртгэгдсэний дотор 121 зүйл нь өндөглөж зусдаг зүйл байна.

Биогеографийн хувьд судалгаа хийсэн нутгийн жигүүртний аймагт палеарктик 45%, зүүн палеарктик 30%, голарктик 17% эзэлж байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа нь 295981.5 га талбай бүхий газар нутгийг хариуцан хамгаалдаг. Үүний 292905.5 га нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар, 3076 га нь Нагалхааны байгалийн нөөц газар юм. Байгалийн өвөрмөц тогтоц, биологийн төрөл зүйл, экосистемийн онцлог төрх, түүх соёлын өв, нийслэл Улаанбаатар хотын ундны цэвэр усны нөөцийг хамгаалах зорилготой байгуулагдсан. Тус газрыг УИХ-ын 1993 оны 83-р тогтоол, Засгийн газрын 1994 оны 9-р тогтоолоор Горхи-Тэрэлжийн БЦГ-ыг байгуулж, улсын тусга хамгаалалттай газрын сүлжээнд авсан байна.

“Аянчин Лодж” жуулчны бааз нь Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6 дугаар хороо, Горхи –Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Эрээний адаг нэртэй газарт 12 га талбайд хэрэгжиж байна.

Нийгэм, эдийн засаг. “Аянчин Лодж” жуулчны бааз нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэр Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Эрээний адаг

нэртэй газарт хэрэгжиж байна. Тус жуулчны бааз хүртэл Улаанбаатар хоттой засмал замаар холбогдсон. Улаанбаатар хотоос 51.3 км, Налайх дүүгээс 15 км зайд оршино. Улаанбаатар - Тэрэлжийн төв засмал замаас салаад сайжруулсан шороон замаар 0.6 км явж хүрдэг. Энэхүү замын засварыг жил бүр өөрийн хөрөнгөөр засаа сайжруулдаг.

Горхи Тэрэлжийн тусгай хамгаалалттай бүс нутагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй жуулчны баазуудаас гадна хүүхдийн зуны зуслан, хэд хэдэн байгууллагын ажилчдын амралтын газрууд байрладаг

Жуулчны баазад хамгийн ойр орших суурин газар нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн төв юм. Тус дүүрэг нь нийслэлээс зүүн урагш 33 км-т оршдог, 9 дүүргийн нэг бөгөөд 7 хороотой. Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 68.7 мян.га ба 37715 хүн амтай.

Дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, Улаанбаатар хоттой төмөр зам, авто замаар холбогдсон, дулааны хангамж цэвэр усны найдвартай эх үүсвэртэй Монгол улсын зүүн өмнөт хэсгийг хангах 220 квт цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам, холбооны шилэн кабель, дайран өнгөрдөг эдийн засгийн зангилаа нутаг юм. Улаанбаатар хотын цэвэр усны дээд эх үүсвэртэй шууд холбогдсон. Олон улсын болон хот хоорондын электрон АТС-тэй, электрон шуудан интернэтийн сүлжээ, мобиком, скайтел гар утасны сүлжээнд орсон 60 гкал- цаг дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай дулааны станцтай. Дэлхийн аль ч улс оронтой богино хугацаанд харилцаж болох харилцаа холбоо бүрдсэн дүүрэг юм.

Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутаг хамаардаг, хүн амын дийлэнх олонхийг залуучууд болон хөдөлмөрийн насныхан эзэлдэг, нүүрс, алт, цагаан тугалга, болор, шохой, рашаан ус этийн ургамал, элс, шавар, хайрга зэрэг байгалийн баялаг ихтэй зэрэг давуу тал олонтой дүүрэг юм.

Газрын гадарга, хэвлий. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй нөлөөлөл нь баазын үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа эзэмшлийн 9 га талбайн газрын гадарга техноген үйл ажиллагаанд өртөгдөж болзошгүй юм.

Агаарын чанар. Төслөөс агаарын чанарт үзүүлэх болзошгүй нөлөөлөл нь баазад ирсэн жуулчид хог хаягдлыг замбараагүй хаях, хог хаягдлын цэг болон цэвэрлэх байгууламжаас орчинд эвгүй үнэр гарах, амьдрах орчны тав тухыг алдуулах зэрэг болно.

нь тээвэрлэж зайлуулаагүйгээс бохирын цооног халих, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөгт нөлөөлөх, худгийн эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс худаг бохирдох зэрэг болно.

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг. Тус жуулчны бааз нь Байгаль орчин, Аялал жуулчлалын яамнаас 2017 оны 09 сарын 07-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт ачлал жуулчлалын зориулалтаар газар ашиглах 0160853 дугаартай гэрчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 09 сарын 07 өдрийн А/263 дугаартай тушаалаар 5 жилийн хугацаатай авсан ба 2017 оны 09 сарын 25-ны өдөр Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээг Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг дарга, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын захиргаа олгосон.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ									
1	Горхи-Тэрэлжийн БЦГ орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар, агаар дахь тоосны хэмжээ ихсэж, орчны хүчилтөрөгчийн хэмжээ багасах, үйлчлүүлэгч, байгууллагын үйлчилгээний автомашины шатах тослох материалын ууршилт, утаа,	Байгууллагын түгээлтийн болон ажилтнуудын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулж, нүүрсэн яндан болон утаа шүүнч, оч баригч тавих	Машин техникүүд	ш	Дотоод төлөвлөлтөөр			2025	Агаарын ба агаарын бохирдлын тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 /хүн ам суурьшсан хэсгүүдэд/ Бензин хөдөлгүүрт MNS5013:2009 Дизель хөдөлгүүрт MNS5014:2003/ЗГ-ын 2009 оны351 дүгээр
2	тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, цэвэрлэх байгууламж болон бохир ус дамжуулах хоолой, бохир ус цуглуулах хэсгийн битүүмж муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно.	Төслийн хугацаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг оношлогоонд цаг тухай бүрт нь оруулж, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх		ш	Дотоод төлөвлөлтөөр			2025	тогтоолын хавсралт -Ус ашигасны төлбөрийн хувийн хэмжээ/ - Байгаль хамгаалах тухай хууль - Агаарын тухай хууль - MNS 4585:2016
3		Хуурай хог хаягдлыг ил задгай шатаахгүй байж, зориулалтын цэгт зайлуулах.		-					2025

		Бохирын цооног, дамжуулах хоолойн битүүмжийг сайжруулж, эвдрэхээс сэргийлэх	Төслийн хүрээнд		Дотоод төлөвлөлтөөр				-Зөрчлийн тухай хуулийн бдугаар бүлгийн 6.1-ийн 2
4	Тоосжилт	Тоосжилтыг бууруулах зорилгоор хуурайшилттай үед зам талбайг тогтмол усал байх	Төслийн хэмжээнд	удаа	10.0	10	100.0	2025	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө									
5	Хөрс бохирдох	Хог хаягдлын нэгдсэн битүүмжлэлтэй цэг байгуулах	Хогийн цэг	ш	Хог хаягдлын менежментийн зардалд тусгана			2025	Хог хаягдлын тухай хууль
6	Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Талбай болон ойр орчинд авто болон явган салаа зам үүсгэхгүй тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах	Төслийн талбай	ш	100.0	2	200.0	2025	
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө									
7	Ургамлан нөмрөгийн талхлагдал	Шаардлагагүй салаа зам гаргаж, нүх ухаж, хөрс гэмтээж ургамлан нөмрөг талхлагдахаас урьдчилан сэргийлэх	Төслийн талбай	Га	Дотоод төлөвлөлтөөр			2025	

Усан орчинд үзүүлэх нөлөллийг бууруулах төлөвлөгөө									
8		Усыг зүй зохистой хэрэглэх санамж, анхааруулга, мэдээллийг түгээх хэрэгжүүлэх	Усан хангамжийн эх үүсвэр	Дотоод төлөвлөлтөөр				Тогтмол	
9	Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Усны чанар, нөөцийн мониторинг хийх		Удаа	ОХШХ-т тусгасан	-		ОХШХ-т тусгасан давтамжаар	Улсын усны мэдээллийн сан, бүрдүүлэх үзүүлэлт, хөблөх журам /БОНХС-ын 2014 оны А-86 дугаар тушаалын хавсралт/
10	Ус бохирдож улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Усны эх үүсвэрийг хамгаалах, эрүүл ахуйн бүсийн дэглэм тогтоох, хэвшүүлэх, ойр орчныг цэвэрлэх, хог хаяндлаар бохирдуулахгүй байх	Унд ахуйн худаг	ш	200.0	2	400.0	1 удаа	БОНХАЖ-н сайд, БХБ-н сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал
11	Хүн бороо, үерийн усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материалын үлдэгдэл угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон машин техникийн бүрэн бүтэн байдал, хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавих, асгарч алдагдсан тохиолдолд	Зогсоол хогийн цэгийн орчим	-	100.0	-	100.0	Тухайн бэлтгэсэн хэрэгсэл, материал дуусах болон ашиглалтаас гарах бүрд	Усны тухай хууль, 22.1, 23.1, 24.1 зүйл заалт

		ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах							
НИЙТ ЗАРДАЛ					100.0+200.0+100.0+400.0=800.0				

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг.

Төсөл хэрэгжүүлэгч нь ногоон байгууламжийг 1657м² талбайд байгуулсан байна.

Хүснэгт 6. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мянг.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Мод бутны арчлалт хамгаалалт	Ургаагүй мод бутыг нөхөн тарих аргачлалт хийх	Төслийн талбайд	удаа	2	200.0	400.0	2025 оны 5р сард	
2	Агч модны суулгац	1-2 настай суулгац шинээр суулгах замаар өргөжүүлэх		ш	100	30.0	6.000.00	2025 оны 10р сард	
3	Монос модны суулгац			ш	100				
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг					6.400				



Мод тарих хэсэг

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх сочлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палентологийн

Олдвор одоогоор тохиолдоогүй байна.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурмгалт зүйл илэрсэн үед “Монгол улсын үндсэн хууль”-ийн 1р бүлгийн 7-р зүйлд “Монгол ард түмний түүх, сочлын дурсгалтай зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны түүх соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн Засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холботоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанд ахуйн угаалгын / саван, шампунь, угаалгын нунтаг/ одисоос өөр химийн болон цацраг идэвхит бодис хэрэглэгдэхгүй. Тиймээс ахуйн угаалгын бодисоо зориулалтын газар хадгалж, хог хаягдлыг зохих журмыг дагуу зайлуулах шаардлагатай.

Манай улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиолддог байна. Сүүлийн 30жилийг 3 арван жилд хувааж 1 жилд тохиолдох цаг агаарын аюулт гамшигт үзэгдлийн давтамжийг дундажлан үзэхэд эхний 10 жилд 15 удаа, 2дахь арван жилд 40 удаа, сүүлийн 10 жилд 78 удаа тохиолдов. Тэдгээрээс уруйн үер 21%, салхи шуурга 21%, аянга цахилгаан 14%, нөөлөг салхи 10%-ийг эзэлж байна.

Осол эрсдэлээсхамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга, бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой.

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Үйл ажиллагаатай холбоотой аюул, осол эрсдэл						
1	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж иж бүрэн байлгах	Гал түймрийн осол аюулаас урьдчилан сэргийлж, сургалтыг жилд 2 удаа зохион байгуулж байх	Төслийн хүрээнд	200.0	Жилд 2 удаа	MNS 5566:2005 гал түймрээс хамгаалах, ААН байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх, шаардлага норм
Байгалийн гаралтай аюул, эрсдэл						
2	Газар хөдлөлт, аянга цахилгаанд нэрвэгдэх	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны бүрэн байдлыг хангах. Аянга зайлуулагчийг өндөр газар байрлуулах	Үйл ажиллагааны явцад тогтсон хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр		Гамшгаас хамгаалах тухай хууль, гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө нийт зардал				200.0		

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Жуулчны бааз нь хатуу хог хаягдлын цэгийг байгуулахдаа модон хавтан, төмөр дээрээр битүү байшин барьж хог хаягдлыг тээвэрлэх хүртэл орчинд эвгүй үнэр тархах, салхи, уснаас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Зураг 8

Хог хаягдал хадгалах байшинг угсрахдаа 2 тасалгаатай барьсан бөгөөд том тасалгаанд дахин ашиглах боломжгүй хог хаягдал, жижиг тасалгаанд дахин боловсруулах боломжтой буюу дахивар бүтээгдэхүүнийг хадагладаг байна.

Хог хаягдал хадгалах байгууламж нь маш сайн битүүмжлэгдсэн бөгөөд нэг хүнээс хоногт дунджаар 1.5-2 кг хуурай хог хаягдал гарна гэж тооцож тусгай бэлтгэсэн тасалгаанд хадгалж тухайн хогийн хэмжээнээс шалтгаалан сард нэгээс доошгүй удаа /ачаалал ихтэй үед 7-14 хоног тутам/ зөөвөрлөн Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тэй байгуулсан “Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ”-ний дагуу зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулан ажиллаж байна

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөлийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	- Ангилсан хог түр хадгалах цэг тохижуулах - Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх	Төслийн үйл ажиллагаа	тн	50.0	2	100.0	2025	“Хог хаягдлын тухай хууль” Энгийн хог хаяглыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
2	Ариутгал, халдваргүйжүү- лэлт хийх	Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Төслийн хэмжээнд	ш	20.0	3	60.0	2025	
3	Хог хаягдал зайлуулах	Хогийг зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх	Талбайн хэмжээнд	Удаа	220.0	12	2.640.0		
Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нийт зардал, төг 2.800.0									

ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАН ЯЛГАХ ЗӨВЛӨМЖ



Зураг 9. Хог хаягдлаа дээрх өнгө бүхий хогийн саванд цуглуулах

Ангилал бүхий хогийн савны амыг салхинд тараахгүй байхаар бат бөх зориулалтын битүү тагтай байрлуулах хэрэгтэй. Ил кадгай хог хаяхгүй байх талаар анхаарулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэлт хийх шаардлагатай. Хогийн цэгийн ойролцоо гал унтраагуурын багаж хэрэгсэл байршуулах хэрэгтэй.

Хуурай хог хаягдлыг 100% ангилан ялгаж, дахиварт хүргэн ачилтаар хүргэгдэх хог хаягдлыг 50-60% хүртэл бууруулах.

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга,аргачлал
1. Агаарын чанар								
1	Агаарын чанарын шинжилгээ хийлгэж байх	- дотоод орчинд - авто зогсоолд -амрагчдыг байр хооронд	Хагас жил тутам	2	351.700	703.400		
2. Гадаргын болон газар доорх усны чанар								
1	Газрын доорх усны бактерлогийн бүрэн шинжилгээ	Гүний худаг	Хагас жил тутам	2	168.080	336.160		
3. Хөрс, хөрсөн бүрхэвч								
1	Хөрсний бохирдлын шинжилгээ /11 элемент/	- Хогийн цэгийн орчим -Цэвэрлэх байгууламжийн орчим -Авто зогсоолын орчим	Хагас жил тутам	2	70.0	140.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх нь зүйтэй	MNS5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS5850:2019 “Хөрс бохирдуулагч, бодис элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”
2	Хөрсний ерөнхий шинжилгээ /агрохими, механик бүрэлдэхүүн /	- Ногоон байгууламж - Талбайн эрүүл хэсэгт	Хагас жил тутам	2	70.0	140.0		
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх 5 жилийн гүйцэтгэлийн зардал						1.319.560		



Зураг 9. орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан мониторингийн цэгүүд

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах үорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь “Аянчин фоор сийзонз лодж” ХХК-ийн “Аянчин фоор сийзонз лодж” аялал жуулчлалын төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд:

- ✓ Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрд үзүүлэх нөлөөлөл
- ✓ Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд
- ✓ Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр
- ✓ Хяналт шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил
- ✓ Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж
- ✓ Хяналт шинжилгээ явуулах арга_ аргачлал
- ✓ Хяналт шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж
- ✓ Хяналт шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэрбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлө, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх араг хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодит мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Ийнхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2011 оны 2-р сарын 16-ны өдрийн БОАЖЯ-ны сайдын А-36 тоот тушаал “Журам шинэчлэн батлах тухай

/Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам/-ыг удирдлага бологон ашиглав.

НЭГ. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

1.1. Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд

- ⊕ Хүснэгтээс харна уу.

1.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр

- ⊕ Сорьц авах
- ⊕ Хэмжилт хийх

1.3. Байршил

- ⊕ Хүснэгтээс харна уу

1.4. Хэрэглэгдэх багаж

- ④ Сорьц авах, тоос шахуурга, бага хурдтай дээжлэгч иж бүрдэл, хийн сорьц цуглуулах уут эсвэл лициндр
- ④ Шууд хэмжлийн багаж
 - 1.5. Хийх ажлын дараалал
 - ④ Тогтоосон хугацаанд сонгосон цэгт багажийг байрлуулна.
 - ④ Орчны бичиглэл хийнэ. Цаг агаарын төлөв байдлын талаар оряны бтчиглэл хийнэ.
 - ④ Хэмжилт хийх үеийн агаар, хөрсний температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хөтөлнө.
 - ④ Зориулалтын автомат багажийн тусламжтайгаар хэмжилтийг гүйцэтгэнэ.
 - 1.6. Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж
 - ④ Хүснэгтээс харна уу
 - 1.7. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал
 - ④ MNS 5003:2000. Чимээ шуугианы-Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй. Чимээ шуугианыг хэмжих
 - ④ MNS 5803:2007. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Ажлын байрны агаар дахь хар тугалганы агууламж, ажлын байранд тавигдах шаардлага
 - ④ MNS 3384:1982 Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага
 - ④ MNS 5365:2004 Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга
 - ④ MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй.Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.
 - ④ Бусад хамаарах аргачлал
 - 1.8. стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ
 - ④ Эрүүл ахуйн хяналтын улсын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдах “хот суурингийн агаар дахь бохирдуулах бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд төвшин”
 - ④ MNS 5803:2007. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй Ажлын байрны агаар дахь хар тугалганы агууламж, ажлын байранд тавигдах шаардлага
 - ④ MNS5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.
 - ④ MNS5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага
 - ④ MNS 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.

- ③ MNS 5078:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй.
Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага.

ХОЁР.УСНЫ ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭ

2.1. Хяналт-шинжилгээ явуулах үзүүлэлт

- ❖ Хүснэгтээс харна уу

2.2. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр

- ❖ Сорьц авч шинжилгээ хийлгэх

2.3. Байршил

- ❖ Хүснэгтээс харна уу

2.4. Хэрэглэгдэх багаж төхөрөмж

- ❖ Дээжлэгч болон цэвэр усны шил, сав
- ❖ Бактерлогийн дээжийг ариутгасан зориулалтын саванд авна.

2.5. Хийх ажлын дараалал

- ❖ Усны дээж авах саваа бэлтгэнэ, сайтар цэвэрлэсэн байна
- ❖ Дээж авах гэж буй усаар сав болон бөглөөг 2-3 удаа зайлна
- ❖ Дээж авалт бүр хаягтай байна
- ❖ Итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

2.6. Хяналт- шинжилгээ явуулах хугацаа график

- ❖ Хүснэгтээс харна уу

2.7. Хяналт шинжилгээ явуулах, аргачлал

- ❖ MNS ISO 7150-1:2006. Байгаль орчин. Усны чанар. рН-г тодорхойлох. 1-р хэсэг. Хялбар ажиллагаатай спектрометрийн арга.
- ❖ MNS 4423:1997. Ундны ус. Хуурай үлдэгдэл тодорхойлох арга
- ❖ MNS ISO 6060:2001. Байгаль орчин. Усны чанар. Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох.
- ❖ MNS ISO 5815:2001. Байгаль орчин. Усны чанар. Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийг 5 өдрийн дараа тодорхойлох. Шингэлэх ба ургуулах арга.
- ❖ MNS 5597:2006. Арьс шир арьс ширний үйлдвэрийн техонлогийн хаягдал усанд сульфид тодорхойлох арга.
- ❖ MNS ISO 11083:2001. Байгаль орчин. Усны чанар-хром тодорхойлох 1,5-дифенилкарбазид ашигласан спектрометрийн арга.
- ❖ MNS ISO 11885:2011. Усны чанар. Сонгосон элементүүдийн индукцийн холбоотой плазм оптикийн цацаргалтын спектрометрийн аргаар тодорхойлох.

- ❖ Бусад хамаарах аргаар тодорхойлох
- ❖ MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.
- ❖ MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- ❖ MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
- ❖ MNS 4943:2015 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
- ❖ Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015

ГУРАВ. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

3.1. Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт

- ⊕ Хүснэгтээс харна уу.

3.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр

- ⊕ Сорьц авч шинжилгээ хийх

3.3. Байршил

- ⊕ Хүснэгтээс харна уу

3.4. Хийх ажлын дараалал

- ⊕ Дээж авахаар сонгосон талбайд /0-20/ см-ийн гүнээс тус бүр /300-500/ гр хөрсийг хүрз, хусуур, өрмийн багажийн аль нэгийг хэрэглэн дээжийг авна.
- ⊕ Үлдвэр үйлчилгээний байгууллагуудын орчмын рөхснөөс шинжилгээнд дээж авах гүний хэмжээ /0-15, 0-25/ см байна.
- ⊕ Үйлдвэр ахуйн гаралтай хог, хаягдал, бохир ус, шим бохирдол, бордоо химийн хорт болон цацараг идэвхит изотопоор бохирдсон талбайн хөрснөөс дээж авах гүний хэмжээ /0-25, 0-50/ см 1,0 м байна.
- ⊕ Орчин, хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авна.
- ⊕ Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийнэ.
- ⊕ Дээж авалт бүрт солбицол бичсэн байна.
- ⊕ Итгэмжлэгдсэн лаборатоид хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

3.5. Хяналт шинжилгээ явуулах хугацаа, график

- ⊕ Хүснэгтээс харна уу

3.6. Хэрэгдэгдэх багаж төхөөрөмж

- ⊕ Зүсэлт хийх хүрз
- ⊕ Хөрс дээжлэгч уут, сав

- ④ Фото аппарат
- ④ Самбар маркер

3.7. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал

- ④ MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
- ④ MNS 3310:1991 хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
- ④ MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
- ④ MNS 2305:94 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам

3.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- ④ MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- ④ MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- ④ С 5916:2008, Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
- ④ MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэг 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага,зохион байгуулалтын зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар 2024 он				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			I улирал	Пулирал	III улирал	IV улирал		
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх. Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа	200.0			+		Талбай хариуцсан эрхлэгч	Байгаль хамгаалах тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль
2	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоногдолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	200.0			+	+	Талбай хариуцсан эрхлэгч	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16р зүйлийн 16.1.7 дахь заалт
3	Ус ашиглуулах дүгнэлтийг Нийслэлийн байгаль орчны газраар гаргуулах	-			+	+		
Нийт зардал		400.0						

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙННӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ


БОМТ-г БОАЖ сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж хянуулан батлуулах ба биелэлтийг тайлагнана. Үүнд:

Налайх дүүргийн 6-р хорооны ИНХ, төслийн талбай орчим оршин суугчид тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг тайлагнана.

Хүснэгт 12. Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
	БОМТ-ний биелэлтийн тайлан	Цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр дүн, дараа жилийн БОМТ	Дараа жилийн 11 сарын 1-ний дотор	Хариуцсан Мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардлаар	Төслийн талбай
	Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоо	Хэвлэмэл болон цахим тайлан		Дараа жилийн 11р сарын 15-ны дотор			Хорооны Иргэдийн нийтийн хуралд
	Налайх дүүргийн 6-р хорооны ИНХ	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга		Дараа жилийн 11 сарын 1-ний дотор			
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн					Дотоод төлөвлөлтөөр		

БАТЛАВ. БОАЖА-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Г. ЭНХМӨНХ



ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

"АЯНЧИН ФООР СИЙЗОНЗ ЛОДЖ" ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г. БИЛГҮҮН

**Нийслэлийн Налайх дүүргийн 6 дугаар хорооны
нутаг дэвсгэрт байрлах " Аянчин фоор сийзонз
лодж " аялал жуулчлалын төслийн
2022-2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

"ЭХМОНГОЛЫН БАЙГАЛЬ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ



М. ДЭЛГЭРМАА

1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

БОМТ-НИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь “Аянчин фоор сийзонз лодж” аялал жуулчлал төслийн байршиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм. Тиймээс төслийн үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөсөн БОМТ-г төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлөө бүрдүүлэх нь энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго болно.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхийн хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
- БОМТ-ний хэрэгжилтийг компанийн удирдлага өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр “Аянчин фоор сийзонз лодж” аялал жуулчлал төслийн хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.

БОМТ-НИЙ ГОЛ ЗАРЧИМ

БОМТ-г боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаа нь БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдөр баталсан А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтална.

Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9-р зүйлийн 8-р заалт: “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

БОМТ-НИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

БОМТ нь “Аянчин фоор сийзонз лодж” аялал жуулчлал төслийн үйл ажиллагааны хэмжээнд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын дагуу хэрэгжих бөгөөд БОННУ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон байгаа.

Төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий энэ төлөвлөгөөнд БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрээн дэх бүхий л асуудлыг хамрахад БОМТ нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ),
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө.

Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө;
- ✓ Орчны тохижилт, өргөтгөлийн дараах нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө;
- ✓ Төслийн талбай орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;
- ✓ Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежмент;
- ✓ Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежмент;
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ;
- ✓ Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт;
- ✓ БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт;

Төлөвлөлтийг ойрын 5 жилээр хийж, холбогдох зардлыг мөн ойрын 5 жилээр тооцно.

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ									
1.	Горхи-Тэрэлжийн БЦГ орчмын авто машины хөдөлгөөн ихэссэнээс агаар, агаар дахь тоосны хэмжээ, CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн (O ₂) хэмжээ багасах,	Машин техникуудийн янданд шүүлтүүр суурилуулж, найдвартай ажиллагааг хангах, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих болон янданд оч баригч хийх	Машин техникууд	ш	Дотоод төлөвлөлтөөр		2022-2026 онд Жил бүр	- Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3- 16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт – Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ - Байгаль хамгаалах тухай хууль - Агаарын тухай хууль, - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1-ийн 2	
2.	үйлчлүүлэгч, байгууллагын үйлчилгээний автомашины шатах тослох материалын ууршилт, утаа, тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно. Барилга байгууламж байгуулах үеийн газар шорооны ажлаас тоосжилт үүсэх	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтад тогтмол оруулж,засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх		ш	Дотоод төлөвлөлтөөр		2022-2026 онд Жил бүр		
3.		Хуурай хог хаягдлыг хогийн цэгт зайлуулахгүйгээр шатаахыг хориглоно	Төслийн хэмжээнд	-	Дотоод төлөвлөлтөөр		2022-2026 онд Байнга		
4.	Тоосжилт	Тоосжилтыг бууруулах	Төслийн	удаа	10.0	10	100,0		2022-2026 онд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		зорилгоор хуурайшилттай үед зам талбайг тогтмол усалж байх	хэмжээнд					Хуурай-шилттай үед	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө									
5.	Хөрс бохирдох	Хог хаягдлын нэгдсэн цэг байгуулах	Хогийн цэг	ш	Хог хаягдлын менежментийн зардалд тусгана			2022-2024 онд	Хог хаягдлын тухай хууль
6.	Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Талбай болон ойр орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн сүлжээг сайжруулж, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Төслийн талбай	ш	100,0	2	200,0	2022-2023 онд Барилгын ажлын үед	-
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө									
7.	Ургамлан нөмрөгийн талхлагдал	Байшин, барилга барих, явган замаас бусад талбайн ургамлыг талхлагдлаас хамгаалах	Төслийн талбай	га	Дотоод төлөвлөлтөөр			2022-2026онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
8.		Шаардлагагүй салаа зам гаргаж ургамлыг талхлагдахаас урьдчилан сэргийлэх	Төслийн талбай	га	Дотоод төлөвлөлтөөр			2022-2026 онд	
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө									
9.	Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Усыг зүй зохистой хэрэглэх санамж, анхааруулга, мэдээллийг түгээх, хэрэгжүүлэх	Усан хангамжийн эх үүсвэр	Дотоод төлөвлөлтөөр				Байнга	-
10.									
11.		Усны чанар, нөөцийн мониторинг хийх			удаа	ОХШХ-т тусгасан		-	ОХШХ-т тусгасан давтамжаар

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									тушаалын хавсралт)
12.	Ус бохирдож улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Усны эх үүсвэрийг хамгаалах, эрүүл ахуйн бүсийн дэглэм тогтоох, хэвшүүлэх, ойр орчныг цэвэрлэх, хог хаягдлаар бохирдуулахгүй байх	Унд ахуйн худаг	ш	200.0	2	400.0	1 удаа	БОНХАЖ-н сайд, БХБ-н сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал,
13.	Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь хог хаягдал, шатах тослох материалын үлдэгдэл угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон машин техникийн бүрэн бүтэн байдал, хог хаягдлын хадгалалтад тогтмол хяналт тавих, асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах	Зогсоол, хогийн цэгийн орчим	-	100.0	-	100.0	Тухайн бэлтгэсэн хэрэгсэл, материал дуусах болон ашиглалтаас гарах бүрд	Усны тухай хууль, 22.1, 23.1, 24.1 зүйл заалт
14.	Газар доорх шугам хоолой гэмтсэнээс ахуйн ус хөрсөнд нэвчиж, газрын доорх усны найрлага, шинж чанарт нөлөөлөх	Ахуйн ус дамжуулах шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтад байнга хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд засах арга хэмжээ авч ажиллана.	Төслийн талбай болон Гүний хоолойн шугам сүлжээ	Хяналт шалгалтын тоо, шалгалтаар илэрсэн зөрчлийн тоо	1,000,000	Тодорхойлох боломжгүй	1000.0	5 жилийн турш	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, 14.2.1, 14.2.2, 14.2.4-р зүйл заалт
15.	Үерийн эрсдэл	Төслийн талбайн хойд, урд хэсгээс үер орж ирэх магадлалтай тул үерийн сувгийг шаардлагын	Төслийн талбай	-	Мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдсөний эцэст тухайн жилийн БОМТ—д тусгах замаар шийдэх			2022-2024 он	-

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		төвшинд мэргэжлийн байгууллагаар зураг төсөл хийлгэх							
НИЙТ ЗАРДАЛ			100,0*4жил +400,0+200,0+100,0+1,000.0=2,100.0						

2. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Төсөл хэрэгжүүлэгч нь ногоон байгууламжийг 1657м² талбайд байгуулсан байна.

Хүснэгт 2. Нөхөн сэргээлт, тохижилтын төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал ¹ , төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Мод бутны арчлалт хамгаалалт	Ургаагүй мод бутыг нөхөн тарих арчлалт хамгаалалт хийх	Төслийн талбай	удаа	2	200.000	400.0	2022-2024 онд 5, 10 сард	
2	Хар модны тарьц	дотоодоос сэлгэн шилжүүлэх, нөхөн үржүүлэх замаар өргөжүүлэх		ш	100	30,0	6,000,00	2023-2026 онд 5, 10 сард	
3	Шинэс			ш	50				
4	Нохойн хошуу			ш	50				
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг				6,400.0					

¹ <http://ecoline.tcgroup.mn/index.php/en/2013-04-30-23-44-01>

3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

Хүснэгт 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8
1.	Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл олборлох ажлаа зогсоож энэ тухай, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	2022-2026 он	-	Бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд нэмэлтээр тусгах		Тухайн үед нь шийдэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанд ахуйн угаалгын (саван, шампунь, угаалгын нунтаг) бодисоос өөр химийн болон цацраг идэвхит бодис хэрэглэгдэхгүй. Тиймээс ахуйн угаалгын бодисоо зориулалтын газар хадгалж хог хаягдлыг зохих журмын дагуу зайлуулах шаардлагатай.

Манай Улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиолддог байна. Сүүлийн 30 жилийг 3 арван жилд хувааж, 1 жилд тохиолдох цаг агаарын аюулт, гамшигт үзэгдлийн давтагдлыг дундажлан үзэхэд эхний 10 жилд дунджаар (1989-1998 он) 15 удаа, 2 дахь 10 жилд (1999-2008 он) 40 удаа, сүүлийн 10 жилд (2009-2018 он) 78 удаа тохиолдов. Тэдгээрээс уруйн үер 21%, салхи шуурга 21%, аянга цахилгаан 14%, нөөлөг салхи 10%-ийг эзэлж байна.

Тэрэлж орчмын хувьд 2005-2019 оны мэдээгээр:

- 2006 оны 6 сарын 28нд хүчтэй аадар бороо орж Тэрэлж чиглэлийн Туул голын гүүр эвдэрсэн.
- 2013 оны 6 сарын 24нд Тэрэлжийн орчим их хэмжээний бороо орж үер буун айлууд, машинууд усанд автсан.

Төслийн талбайн урд хэсгээр нэргүй сайр өнгөрч байгаа мөн хойд талаараа уулаар хүрээлэгдсэн мөн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчим нь хур тунадас элбэг бүс нутаг тул үерийн эрсдэл үүсэх магадлал 100 жилд 1 байна.² Иймээс төслийн эргэн тойронд далан шуудуй, аянга зайлуулагчийг байгуулах шаардлагатай байна.

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Үйл ажиллагаатай холбоотой аюул, осол эрсдэл						
1	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж иж бүрэн байлгах	Гал түймрийн осол, аюулаас урьдчилан сэргийлж, сургалтыг жилд 2 удаа буюу хавар, намрын улиралд зохион байгуулж байх	Төслийн хүрээнд	1,500.0	жилд 2 удаа	MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. ААН, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж

						хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
Байгалийн гаралтай аюул, эрсдэл						
1	Үерийн усанд автах	Үерийн ус зайлуулах суваг шуудуу байгуулах, найдвартай байдлыг жилд 1 удаа шалгаж байх	Үйл ажиллагааны явцад тогтмол	-	2022-2026 он	БНбаД 40-01-06. Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж
2	Газар хөдлөл	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах		Дотоод төлөвлөлтөөр	Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр	
3	Аянга цахилгаанд нэрвэгдэх	Аянга зайлуулагчийг ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах, цахилгаан дамжуулах хийцлэлтэй материалтай болон цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх, Аянга зайлуулагчийн хэвийн ажиллагааг 1 удаа мэргэжлийн байгууллагаар шалгуулж, найдвартай ажиллагааг хангах	Үйл ажиллагааны явцад тогтсон хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	Утсан холбооны төхөөрөмж түүн дээр ажиллагсдыг атмосферын цэнэгжилтээс хамгаалах арга MNS 4026:1987	
4	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам мөрдөж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх		Дотоод төлөвлөлтөөр		
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө нийт зардал				1,500.0 мян.төг		

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн цар хүрээ

Баримтлах зарчим. Төслийн үйл ажиллагааны явцад “Хог хаягдлын менежмент”-боловсруулах нь хэрэгжүүлэх бөгөөд энэ нь дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хог хаягдлын тухай Үндэсний болон Олон Улсын нийтлэг хууль, журмыг дагаж мөрдөхөд нийцсэн орчин бүрдүүлнэ.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас болон 2019 оны 5 сарын 07-ны өдрийн “Хог хаягдлын менежмент” Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг дагаж мөрдөнө.

Хог хаягдлыг ангилах. Төслийн үйл ажиллагаанаас дараах төрлийн хог хаягдлууд гардаг бөгөөд одоогийн байдлаар “Хог хаягдлын менежмент”-ийн зураг авалт хийж тоо хэмжээг тодорхойлсон зүйлгүй байна. Төслийн үйл ажиллагаанаас гарах хаягдлыг дараах эрэмбээр ангилна.



Зураг 1. Хог хаягдлын аюулын зэрэглэл, ангилал

Хог хаягдлыг түр хадгалах.

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилах, өөр дээр түр хадгалахад “Хог хаягдлын тухай” хуульд заасан шаардлагад нийцүүлэх бөгөөд хуулийн 7 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлд заасан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх” болон Засгийн газрын 2018 оны 116 тоот тогтоол, “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ын хүрээнд хэрэгжүүлнэ.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх

Хог хаягдлын хэмжээг тодорхойлох. Төслийн үйл ажиллагаанаас хоногт дунджаар 133.5кг орчим хог гарна гэж БОННУ-ний “Төслийн товч тодорхойлолт” хэсэгт өгүүлсэн байна. Төслийн талбайн зохион байгуулалтаас шалтгаалан шаардлагатай гэж үзвэл зарим цэгүүдэд нэг төрлийн ангилалын савыг хэд хэдээр зэрэгцүүлэн тавьж болно.



Зураг 2. Хаягдал цуглуулах сав

Хог хаягдлыг зайлуулах. Төслийн үйл ажиллагаанаас хог хаягдлыг зайлуулахад ангилсан нэр төрөл бүрээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хог хаягдал хүлээн авах хоёрдогч зах зээлд болон дахин боловсруулагчид, устгал хийх эрх бүхий этгээдүүдтэй тус бүрчлэн гэрээ хийнэ. Энэ ажлыг төслийн үйл ажиллагаа эхлэхэд хамт хэрэгжүүлж эхлэнэ.

Хог хаягдлын ангилал. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг дээр заасан байдлаар ангилах бөгөөд тэдгээрт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж цогцолборын орчинд хог хаягдлыг ангилах, ангилсан хог хаягдлыг төвөг багатайгаар цуглуулах тухай мэдээллийг үйлчлүүлэгч олон нийтэд мэдээлж сурталчлахын зэрэгцээ хогийн цэгүүдийг оновчтой байршуулж холбогдох тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтойгоор хийнэ.

Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын ангилал

№	Менежментийн ангилал	Цогцолборт үүсэх хог хаягдал	Хог хаягдлыг зайлуулах
1	Дахивар хаягдал	хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл	Дахивар хог хаягдал хүлээн авагчидтай гэрээ хийж хоёрдогч зах зээлд нийлүүлнэ. Гэрээнд ангилсан хог хаягдлын шаардлагад хэрхэн нийцүүлэх тухай асуудлыг тусгана.
		Хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл	
		Элдэв зөөлөн хуванцар, гялгар уут, гялгар баглаа боодол	
		Хувцас, даавуун эдлэл	
		Савхи, резин, мод зэрэг дахин ашиглах боломжит бусад хаягдал	
2	Цаасны хаягдал	сонин, сэтгүүл, дэвтэр	
		бичгийн цаас	
		төрөл бүрийн боодлын цаас, картон	
		сүү, жүүсний тетрапак савлагаа	
3	Хүнсний хаягдал	Нийтийн хоолны үлдэгдэл	Хог хаягдлыг устгах сумын нэгдсэн цэгт нийлүүлэх гэрээ хийж ачилтын хуваарийг тохирно.
		Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл	
		Хэрэглэсэн хүнсний тос	
4	Бусад хаягдал	Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдал: - Нийтийн ариун цэврийн өрөөний хаягдал - Мөн ангилаагүй норсон, хэт бохирдсон хаягдлууд орно.	Септик систем суурилуулна

	Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал; • бохирдсон хөрс, шороо, чулуу, элс, хайрга; • хагарсан барилгын материал	Барилгын ажлын үед гарах хог хаягдлыг гүйцэтгэгч компани хариуцан зайлуулах ажлыг гүйцэтгэнэ.
	Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал	
	Хийн хаягдал: • Машины ашиглалтаас үүсэх хий	Авто машины үзлэг оношилгоо, янданд шүүлтүүр тавих

Хог хаягдлыг зайлуулах хүртэл түр хадгалах нөхцөлийг сайжруулах:

Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг дараах эрэмбээр түр хадгална. Үүнд:

- Үүссэн хог хаягдлыг “Хогийн төвлөрсөн цэг”-т хүртэл эх үүсвэр дээр нь цуглуулж маш богино хугацаагаар хадгална. Эх үүсвэр хаягдал цуглуулах ажиллагаа нь нийтийн үйлчилгээний үед хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулах нөхцөлд нийцсэн байна.
- Хог хаягдлыг “Хогийн төвлөрсөн цэг” нь ангилсан байдлаар түр хадгалах бөгөөд тэдгээрийг эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэл хадгална.
- Түр хугацаагаар хадгалах “Хогийн төвлөрсөн цэг” нь элдэв үнэр гаргахгүй, хог хаягдлыг норгохгүй, хийсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 6. Хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах нөхцөлийг сайжруулах

Нөхцөл	Шаардлага
Эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилах	- Нийтийн үйлчилгээний зам талбайд хог хаягдлыг цэвэрлэж цуглуулахад ангилах боломжит нөхцөлийг бүрдүүлэхэд хог хаягдлын ангиллын олон улсын нийтлэг жишгийг дагана. - Дахин ашиглахгүй бохир хаягдал, хүнсний хаягдлын түр хадгалалт хугацаа болон эргэлтийн хугацааг хамгийн богино байх шийдлийг боловсруулна. - Ангилсан хог хаягдлыг дахин боловсруулах, устгах, эргэлтэд оруулах нөхцөлөөр нь ялган тус тусд нь “эрх бүхий этгээд”-д гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгнө.
Цуглуулсан хог хаягдлыг зайлуулах	- Төслийн талбайн орчинд элдэв амьтан цуглах, идэш хайх нөхцөлийг бүрэн хааж хог хаягдлыг ил задгай байдлаар хадгалахгүй байх болно. - Нийтийн үйлчилгээний зам талбай ажилчид нарт хог хаягдлын менежментийн шаардлага тавьж, тэдгээрийн орчинд үүссэн хог хаягдлыг “Төвлөрсөн хогийн цэгт” хүлээн авна. - Ажлын байрны хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах нөхцөлийг бүрдүүлж ажиллагсдад “Хог хаягдлын менежмент”-ийг таниулан, ангилсан хог хаягдлыг цэгүүдийн байршлыг зааж, тэмдэгжүүлнэ. - Ангилсан хаягдал бүрийг тусгайлан түр хадгалахад эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэлх эргэлтийн циклийг тооцно. - Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, түр хадгалах, зайлуулах явцад ажлын зураг авалт хийж ангилсан нэр төрөл бүрээр тоо хэмжээг тодорхойлно. - Ил задгай хаягдаж байгаа цэгүүдийн байршлыг хугацаа алдахгүй тогтоож шаардлагатай сав бэлдэх, байршуулах, тэмдэгжүүлэх зэрэг арга хэмжээг хурдан шуурхай авна.
Хог хаягдлын боловсролыг дэмжих	- Нийтийн үйлчилгээний цэгээс хог хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулахад тэмдэгжүүлэлт, мэдээлэл, зар сурталчилгааг оновчтой зөв хэрэглэнэ. - Ил задгай хог хаягдал хаях явдлыг бууруулахад чиглэсэн торгууль шийтгэл оногдуулах, мэдээлэл хүлээн авах, урамшууллын систем бүхий олон нийт рүү чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. - Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг холбогдох ажилтанд давхар үүрэгжүүлнэ. - Шаардлагатай гэж үзвэл нийтийн үйлчилгээний заал, танхимд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх сургагч, ажилтанг тодорхой хугацаагаар ажиллуулна.

Төслөөс гарах хог хаягдлын төрлүүд ба хэмжээ. Энэхүү төслийн хүрээнд дараах энгийн хог хаягдал гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа хэдий БОМТ-ний хүрээнд богино хугацаанд хэрэгжих энэхүү төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэх байдлаар тооцлоо.

Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ

Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал		
Дахин ашиглах боломжтой	цаас	Захиргааны ажилчид ажиллахад гарах бичиг цаасны хаягдлыг тооцоход төслийн 1 жилийн хугацаанд 0.5 тн
	шил	Хүнсний баглаа боодлоос хүн/хон тооцвол 0.6*365хон 78.8 тн
	хуванцар,	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс 78 хүн/сараар тооцвол 0.5*365хон 17 тн
	металл, төмөр	Нийт үүсэх хэмжээнээс: - Ундааны сав баглаанаас 78 хүн 12 сараар 0.3*78*12 гэвэл 0.2тн - Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс тооцоолох боломжгүй байна
Хүнсний хог хаягдал	(гал тогооны хаягдал)	Нийт ажиллагсад болон зочид хүлээн авахад хэрэглээнээс 78 хүн/хон*0.1 кг*365хон тооцоход 2.8тн
Бусад хаягдал	Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	Нийт ажиллагсдын хэрэглээнээс 78 хүн/хон*0.15 кг *365 хон тооцоход 4.3 тн
	Ахуйн хэрэглээнээс гарсан дахин ашиглахгүй шингэн хаягдал	Төслийн үйл ажиллагааны үед хоногт дунджаар Зуны улиралд хоногт дунджаар 17.8 м ³ , сард 534 м ³ , зуны улиралд 4806 м ³ орчим, Өвлийн улиралд хоногт дунджаар 7.8 м ³ , сард 234 м ³ , өвлийн улиралд 702 м ³ орчим, нийт жилд 5508 м ³ ахуйн хэрэгцээний бохир ус гарна.
Аюултай хог хаягдал		
Аюултай хаягдал	Принтерийн хор, батарей, аккумулятор зэрэг ашиглалтаас хаягдаж буй техникийн аюултай хаягдал	Хэрэглээнээс хамаарна, тооцох боломжгүй.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэг-жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	- Ангилсан хог түр хадгалах тохижуулах	Төслийн үйл ажиллагаа	тн	150,000	2	300.0	2022-2026он сард 1 удаа	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
		- Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх		-	-	-	-	-	
		- Хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх		-	-	-	-	-	
3.	Түр хадгалах	Хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах төвлөрсөн цэгийг битүүмжлэн байгуулах	Төслийн хэмжээнд	шир	1,000.0	2	2,000.0	2022 он	
Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нийт зардал, мян.төг									300.0*5+2,000.0=3,500.0

6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь “Аянчин фоор сийзонз лодж” аялал жуулчлалын төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл;
- Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодит мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Ийнхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2011 оны 2-р сарын 16-ны өдрийн БОАЖЯ-ны сайдын №А-36 тоот тушаал “Журам шинэчлэн батлах тухай /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам/-ыг удирдлага болгон ашиглав.

НЭГ. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

1.1. Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд:

- Хүснэгтээс харна уу.

1.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр:

- Сорьц авах
- Хэмжилт хийх

1.3. Байршил

- Хүснэгтээс харна уу.

1.4. Хэрэглэгдэх багаж:

- Сорьц авах тоос шахуурга, бага хурдтай дээжлэгч иж бүрдэл, хийн сорьц цуглуулах уут эсвэл цилиндр)
- Шууд хэмжилтийн багажаар

1.5. Хийх ажлын дараалал:

- Тогтоосон хугацаанд сонгосон цэгт багажийг байрлуулна.
- Орчны бичиглэл хийнэ. Цаг агаарын төлөв байдлын талаар орчны бичиглэл хийнэ.
- Хэмжилт хийх үеийн агаар, хөрсний температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хөтөлнө.
- Зориулалтын автомат багажийн тусламжтайгаар хэмжилтийг гүйцэтгэнэ.

1.6. Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж:

- Хүснэгтээс харна уу.

1.7. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:

- *MNS 5013:2009* Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин - Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга.
- *MNS 5014:2009*. Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга.
- *MNS 5003:2000*. Чимээ шуугианы-Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй. Чимээ шуугианыг хэмжих
- *MNS IEC 17-5-1-21-92*. Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ, дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга
- *MNS 5803:2007*. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Ажлын байрны агаар дахь хар тугалганы агууламж, ажлын байранд тавигдах шаардлага
- *MNS 3384:1982* Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага
- *MNS 5365:2004* Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга

- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.
- Бусад хамаарах аргачлал

1.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ:

- Эрүүл ахуйн хяналтын улсын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдсан “Хот суурингийн агаар дахь бохирдуулах бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд төвшин”
- MNS 5803:2007. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Ажлын байрны агаар дахь хар тугалганы агууламж, ажлын байранд тавигдах шаардлага
- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага
- MNS 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- MNS 5078:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага

ХОЁР. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

2.1. Хяналт-шинжилгээ явуулах үзүүлэлт

- ❖ Хүснэгтээс харна уу.

2.2. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр

- ❖ Сорьц авч шинжилгээ хийлгэх

2.3. Байршил

- Хүснэгтээс харна:

2.4. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- Дээжлэгч болон цэвэрхэн усны шил, сав
- Бактериологийн дээжийг ариутгасан зориулалтын саванд авна.

2.5. Хийх ажлын дараалал

- Усны дээж авах саваа бэлтгэнэ, сайтар цэвэрлэсэн байна.
- Дээж авах гэж буй усаар сав болон бөглөөг 2-3 удаа зайлна.
- Дээж авалт (дээж тус бүр хаягтай байна).
- Итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

2.6. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа график

- ❖ Хүснэгтээс харна уу.

2.7. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:

- *MNS ISO 10523:2001*

- MNS ISO 7150-1:2006
- MNS 4423:1997
- MNS ISO 6060:2001
- MNS ISO 5815:2001
- MNS 5597:2006
- MNS ISO 11083:2001
- MNS ISO 11885:2011
- Бусад хамаарах аргачлал

2.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага,
- MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюул байдлын үнэлгээ
- MNS 4943:2015 “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
- Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015

ГУРАВ. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

3.1. Хяналт - шинжилгээ явуулах үзүүлэлт:

- Хүснэгтээс харна уу.

3.2. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр

- Сорьц авч шинжилгээ хийлгэх

3.3. Байршил

- Хүснэгтээс харна уу

3.4. Хийх ажлын дараалал

- Дээж авахаар сонгосон талбайд (0-20) см-ийн гүнээс тус бүр (300-500) г хөрсийг хүрз, хусуур, өрмийн багажийн аль нэгийг хэрэглэн дээжийг авна.
- Үйлдвэр үйлчилгээний байгууллагуудын орчмын хөрснөөс шинжилгээнд дээж авах гүний хэмжээ (0-15;0-25) см байна.
- Үйлдвэр, ахуйн гаралтай хог хаягдал, бохир ус, шим бохирдол, бордоо химийн хорт болон цацраг идэвхт изотопоор бохирдсон талбайн хөрснөөс дээж авах гүний хэмжээ (0-25; 0-50) см 1,0 м байна.
- Орчин, хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авна.
- Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийнэ
- Дээж авалт (дээж тус бүр гүн, өнгө, ... солбицол бичсэн хаягтай байна)
- Итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

2.5. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, график

- Хүснэгтээс харна уу.

2.6. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- Зүсэлт хийх хүрз
- Хөрс дээжлэгч уут, сав
- Фото аппарат
- Самбар, маркер

3.7. Аргачлал

- MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
- MNS 3310-1991 Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
- MNS 3298-1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
- MNS 2305-94 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам

1.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- MNS 3297: 2019 Хөрс. “Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ”,
- MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт

Эрүүл ахуйн хяналт-шинжилгээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд зааснаар:

- “хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг
- “хөдөлмөрийн эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие мах бодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг
- “хөдөлмөрийн нөхцөл” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг тус тус ойлгох бөгөөд нисэх буудлын ажлын байрны шаардлагыг баталж хэрэгжүүлэн ажиллана. Үүнд тавих хяналт мониторинг нь дараах чиглэлийг хамарна. Үүнд:
 - Ажлын байр доторх агаар солилцоо, дулааны хэвийн байдал
 - Ажлын байр доторх гэрэлтүүлэг
 - Ажлын байр доторх хог хаягдлын цэгүүдийн байршил
 - Ажлын байр доторх зөв, боловсон үйлчилгээний дүрэм журмын танилцуулга, тэмдэгжүүлэлт

Ажлын байрны агаарын орчинд агаарын хэм, хөдөлгөөний хурд, чийгшил, дулааны тархалтын үзүүлэлт тус тус хамаарна. Ажлын байрны температур нь хүйтний

улиралд 10°C-ээс их, дулааны улиралд 10°C-ээс бага байна. Хэмжилтийг шалнаас дээш суугаа ажлын үед 1м, зогсоо ажлын үед 1.5м өндөрт хэмжинэ.

Аргачлал, стандартаар зөвшөөрөгдөх хэмжээ:

- MNS 4990:2000 – Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага
- MNS 4967:2000 – Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 4968:2000 – Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
- MNS 4969:2000 – Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм
- MNS 5080:2001 – Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ
- MNS 5105:2001 – Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
- MNS 5106:2001 – Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга
- MNS ILO-OSH 1:2003 – Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны талаарх удирдамж
- MNS BS 5906 : 2018, Барилга доторх хог хаягдлын менежмент - Ашиглалтын дүрэм

ДӨРӨВ. УРГАМЛЫН МОНИТОРИНГ

Ургамлын мониторингийн ажлын зорилго нь төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөг судлах, учир ч болзошгүй сөрөг нөлөөллийг аль болох бага хэмжээнд байлгахад чиглэсэн менежментийг боловсруулах суурь мэдээлэл болох юм. Ургамлын мониторингийн ажлыг 5-10 сарын хугацаанд сар бүр гүйцэтгэнэ. Мониторингийн цэгийг өмнө хийгдсэн ургамлын мониторингийн цэгүүдийн үзүүлэлттэй харьцуулах зорилгоор аль болох ойр сонгох, төслийн одоогийн газар ашиглалт, бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай уялдуулан байгаль орчны мэргэжилтэн сонгох нь оновчтой.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1. АГААРЫН ЧАНАР								
1.	Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, PM _{2.5} , PM ₁₀) шинжилгээ хийлгэж байх	- Дотоод орчинд - Авто зогсоолын талбайд - Амрагчдын байр хооронд	Хагас жил тутам	2	38,500	194,000	-	- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 17.2.5.12 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ - MNS 5919 : 2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын баус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УСНЫ ЧАНАР								
2.	Газрын доорх усны бактериологийн бүрэн шинжилгээ.	Гүний худаг	Хагас жил тутам	2	90,420	180,840		MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
3. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	- Хогийн цэгийн орчим - Ногоон байгууламж - Амрагчдын байр	Хагас жил тутам	2	38,000	228.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх нь зүйтэй.	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”, MNS 5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”,
2	Хөрсний бохирдлын шинжилгээ /11 элемент/	- Хогийн цэгийн орчим - Цэвэрлэх байгууламжийн орчмоос - Авто зогсоолын орчим		2	35,000	210.0		
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх 5 жилийн гүйцэтгэлийн зардал								812,840*5 = 4,064.2 мянган төгрөг

7. ТАВАН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилан тооцсон төсөв	Хариуцсан албан тушаалтан	тайлбар
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх	Жил бүр	300.0 x 5	Мэргэжлийн байгууллага	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулах
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	Жил бүр	100.0 x 5	-	
3	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Байнга	100.0 x 5	Төсөл хэрэгжүүлэгч	Гал түймрийн аюул, эрсдэлээс бүрэн сэргийлэх
4	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	Жил бүр	дотоод төлөвлөлтөөр	Дүүргийн онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн аюул, эрсдэлээс бүрэн сэргийлэх
5	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10' зүйлийн дагуу байгаль орчны аудитыг хийлгэх	2 жил тутамд	2,000.00	Мэргэжлийн байгууллага	Байгаль орчинтой холбоотой хууль эрх зүйн биелэлт, гарч болох эрсдэлээс сэргийлэх, зөв менежмент төлөвлөх
6	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа	5 жил тутамд	Тохиролцоноор		Газрын тухай хуулийн 58-р зүйл
Нийт зардал, мян.төг			4,500.0		

8. ТАВАН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн тайлан	Цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр үр дүн, дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардлаар	Төслийн талбай
2	Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоо	Хэвлэмэл болон цахим тайлан		Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	хариуцсан мэргэжилтэн		Хорооны Иргэдийн нийтийн хуралд
3	Налайх дүүргийн 6-р хорооны ИНХ	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга		Жил бүрийн 10 сарын 25-ны дотор			
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг					Дотоод төлөвлөлтөөр		

9. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДАЛ

Төслийн үйл ажиллагаанд БОМТ-г хэрэгжүүлэхэд 2022-2026 онд нийт **20,564.2** мян төгрөгийн зардал тооцогдож байна.

БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт тооцсон зардал, мян.төг	Нийт дүнд эзлэх хувь
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2,100.0	10.2
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	6,400.0	31.1
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	0.0
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-	0.0
Түүх соёлын өвийг хамгаалах	-	0.0
Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	-	0.0
Хог хаягдлын менежментийг зохион байгуулах	3,500.0	17.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4,064.2	19.8
Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	4,500.0	21.9
БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	-	0.0
Нийт зардал	20,564.2	100